



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/183

Арвайхээр

Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн
болон гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн
ангийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын Онцгой комиссын ажиллах журам”-ын 3 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэн батлах тухай” 75 дугаар тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн онцгой комиссын бүрэлдэхүүн, тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг нэгдүгээр, комиссын ажиллах журмыг хоёрдугаар, Онцгой комиссын хурлын дэгийг гуравдугаар, Онцгой комиссын гишүүдэд сум хариуцуулсан хуваарийг дөрөвдүгээр, Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тавдугаар, Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиудыг зургадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Онцгой комиссын ажиллах журам болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Онцгой комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын томилгоог сумын Засаг даргын захирамж, байгууллагын дарга (захирлын) тушаалаар шинэчлэн, гүйцэтгэх үүргийг нь танилцуулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, үйл ажиллагааг нь зохицуулж ажиллахыг бүх сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай” А/202 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101026

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 143 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН ТЭДГЭЭРИЙН
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

	Онцгой комиссын бүрэлдэхүүн	Албан тушаал	Чиг үүрэг
1	Дарга	Аймгийн Засаг дарга,	Удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардлагатай арга хэмжээ, хөрөнгийг шийдвэрлэх, төлөвлөх
2	Орлогч дарга	Онцгой байдлын газрын дарга,	
3	Гишүүн	Аймгийн Засаг даргын орлогч	
4	Гишүүн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Нэрвэгдэгсдэд болон гамшиг ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг томилох, ус хоол хүнсээр хангах, үүрэг гүйцэтгэж байгаа автомашин техник хэрэгслийг шатах тослох материалаар хангах
5	Гишүүн	Арвайхээр сумын Засаг дарга	
6	Гишүүн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Гамшигын хохирол хэрэгцээний үнэлгээг үндэслэн олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх байршуулах хадгалах тээвэрлэх хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг хувиарлах хангалтыг зохион байгуулах, шаардлагатай хөрөнгийг зарцуулах
7	Гишүүн	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Холбогдох захирамж, тушаал, шийдвэрийг хуулийн дагуу шуурхай гаргах хэрэгжилтийг хангуулах
8	Гишүүн	Цэргийн штабын дарга	Нүүлгэн шилжүүлэх, хүн хүч хэрэгслийн тооцоог гаргах, дайчилгаа зохион байгуулах
9	Гишүүн	Прокурорын газрын ерөнхий прокурор хууль цаазын ахлах зөвлөх	Эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэм сахиулах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн туслалцаа үзүүлэх
10	Гишүүн	Шүүхийн Тамгын газрын дарга	

11	Гишүүн	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч	Аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх, хүн хүч техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх
12	Гишүүн	Цагдаагийн газрын дарга	Нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх аврах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах
13	Гишүүн	Тагнуулын ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймаг дахь хэлтсийн дарга	Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх цацраг идэвхт болон химийн хорт бодис дэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих ухуулга сурталчилгаа хийх
14	Гишүүн	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга	Хүн, хүч машин техник хэрэгслээр хангах, дэмжлэг үзүүлэх, нийтийн хэв журмыг сахиулах
15	Гишүүн	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Гамшиг, ослын үед хүн амыг түр байрлуулах, хорогдох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, гамшиг ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн шаардлагатай хэрэгцээг тодорхойлох, хангалтыг зохион байгуулах
16	Гишүүн	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчиний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион
17	Гишүүн	Эрүүл мэндийн газрын дарга	
18	Гишүүн	Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал	

			байгуулах, гамшиг ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах
19	Гишүүн	Зооноз өвчин судлалын төвийн дарга	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхтгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээг авах
20	Гишүүн	Мэргэжлийн хяналтын газрын дарга	Гамшиг, ослын голомтод цацраг химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн хэмжилт хийх эрэн хайх аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дүгнэлт гаргах
21	Гишүүн	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	Химийн хоргүй байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдал стандартын шаардлагыг хангуулах, Зудын эрсдэлийг бууруулах.
22	Гишүүн	Мал эмнэлгийн газрын дарга	Мал амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомтод мал амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийг дэглэм тогтоох, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм журамд заавар стандартын дагуу авч хэрэгжүүлэх
23	Гишүүн	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Мал, амьтан ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
24	Гишүүн	УЦУОШТөвийн дарга	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, усыг бохирдох хамгаалах

25	Гишүүн	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд болон аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах
26	Гишүүн	МУЗН-ийн салбарын дарга	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сайн дурын хэсгийг томилж ажиллуулах
27	Гишүүн	ЭБЦТС, ТӨХК-ний салбарын дарга	Гамшиг ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц шугамд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг яаралтай зохион байгуулах
28	Гишүүн	Онги-Ус сувагОНӨААТҮГазрынзах ирал	Цэвэр бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх, дулааны эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
29	Гишүүн	Авто тээврийн төвийндарга	Нэрвэгчдэд тусламжийн бараа, материал тээвэрлэн хүргэх, гамшиг ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх
30	Гишүүн	“ӨВ АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захирал	Гамшиг ослын улмаас нурсан, эвдэрсэн зам гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх, (цасны нурам, мөсний хахаа зайлуулах, нурангинд дарагдсан зам орц, гарцыг чөлөөлөх гэх мэт)
31	Гишүүн	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК-ний Өвөрхангай аймаг дахь газрын дарга	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшигийн аюулын
32	Гишүүн	Монголын цахилгаан холбооны Өвөрхангай аймаг дахь Холбооны газрын дарга	

			тухай зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртэй зарлан мэдээлэл дамжуулах
33	Нарийн бичгийн дарга	Онцгой байдлын газрын орлогч, УСТасгийн дарга,	Хуралдаан зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хуралдааны тэмдэглэл бичиг баримтыг хөтлөх, гарсан шийдвэрийг нэн даруй холбогдох газарт хүргүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах

- оОо-



АЙМАГ ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бүс нутгийн хүчээр хэрэгжүүлэх бололцоогүй болж тусламж, дэмжлэг үзүүлэх талаар албан ёсны хүсэлт тавьсан буюу өөрийн санаачилгаар хүн хүч техник хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангуулах хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.1.Аймгийн онцгой комисс (цаашид "Онцгой комисс" гэх) Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.2.Комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална.

1.3.Комиссыг тухайн аймгийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд орлогч дарга нь аймгийн Онцгой байдлын газрын дарга, суманд тухайн хариуцсан албан тушаалтан байна.

1.4.Комиссын гишүүд нь ажлын үнэмлэхтэй байна.

1.5.Комиссын хурал нийт гишүүдийн 51-иас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана.

1.6.Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар албан даалгавар, тогтоол, хурлын тэмдэглэл, албан бичиг гаргана.

1.7.Комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.8.Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг тухай шатны Онцгой байдлын асуудал эрхэлсэн нэгжийн ажилтан эрхэлнэ.

1.9.Комисс нь албан ёсны тамга тэмдэг, хэвлэмэл хуудаастай байна.

Хоёр. Комиссын эрх, үүрэг

2.1.Комиссын гишүүд дараах үүрэгтэй байна

2.1.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, төрийн бус олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссоос энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2.Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.1.3.Гамшгийн үед цагийн байдалд мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлэлт, дүгнэлт авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж, шийдвэр гаргах.

2.1.4.Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас олгосон бараа материал, тусламжийг хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих.

2.1.5.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж, зохицуулах шаардлагатай нэмэгдэл хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах.

2.1.6.Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед дээд шатны онцгой комисст албан ёсны хүсэлт тавих.

2.1.7.Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

2.1.8.Гамшиг тохиолдсон үед хохирол, хэрэгцээг тодорхойлох, үнэлэх ажлын хэсгийг зохих мэргэжлийн алба хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах

2.2.Комисс дараах эрхтэй байна.

2.2.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хагуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.2.2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

2.2.3.Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэлд судалгаа гаргуулан авах, илтгэл мэдээллийг хурлаараа хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах, хяналт тавих.

2.2.4.Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

2.2.5.Комиссоос болон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу ашиглах.

Гурав. Комиссын зардал

3.1.Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу захиран зарцуулна.

3.2.Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг мэргэжлийн байгууллага, гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээний ажлын хэсэг бусад алба, мэргэжлийн ангийн гаргасан тооцоо судалгаа саналыг үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгө, Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах зардал бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

3.3.Аймаг, сумын онцгой комисс нь гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардагдах нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудал тавихдаа тухайн онд батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгө, Гамшгаас хамгаалах Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлын зарцуулалтын тайлан, санхүүгийн анхан шатны материалыг Улсын онцгой комисст хүргүүлнэ.

Дөрөв. Сумын Онцгой комисст чиг үүрэг хариуцуулах

4.1.Аймгийн Онцгой комиссын ажиллах журмыг үндэслэн сумын Онцгой комиссын ажиллах журмыг сумын Засаг дарга батална.

4.2.Сумын Онцгой комиссын дарга нь Засаг дарга, орлогч дарга нь ЗДТГ-ын дарга байна.

4.3.Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.

4.4.Сумын Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн Онцгой комисст танилцуулна.

4.5.Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг жилийн төсөвтөө тусган зохих журмын

дагуу захиран зарцуулж, зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Онцгой байдлын газар (онцгой комисс)-т ирүүлж байна.

Тав. Бусад зүйл

5.1.Сумын Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссаны дараа тухай бүр аймгийн Онцгой комисст, аймгийн Онцгой комисс нь хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 12 дугаар сард Улсын Онцгой комисст ирүүлнэ.

5.2.Комисс нь дүрэмдээ орон нутгийн онцлогийг тусгасан заалт нэмж оруулж болно.

5.3.Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэдэд захиргааны шийтгэл ногдуулах саналаа эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

- оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 10...
дугаар сарын 18...-ны өдрийн 1772 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны болон бусад байгууллага аж ахуй нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан шуурхай зохицуулахад аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын шийдвэр гаргах хурлыг энэхүү дэгээр зохицуулна.

1.2. Хурлаар хэлэлцэх асуудлыг жил, улирал бүрийн эхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулж төлөвлөгөө боловсруулан батлуулна.

1.3. Комиссын ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хийнэ. Шаардлагатай тохиолдолд цагийн байдалтай холбогдуулан тухай бүрт нь хуралдааныг зарлан хуралдуулж болно.

1.4. Хурлыг шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан газар, хэлтэс, албадыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр тухай бүрт нь хийж болно.

1.5. Онцгой комиссын гишүүд хэлэлцэх асуудлын талаар эрхэлсэн албан тушаалын хэмжээнд бүрэн мэдээлэл бүхий материалыг бэлтгэж, хуралд идэвх санаачлагатай оролцоно.

Хоёр. Хуралд хэлэлцүүлэх асуудалд санал авах

2.1. Хуралд эрхлэх хүрээнийхээ асуудлыг тухайн албан тушаалтан хариуцан оруулна.

2.2. Онцгой байдлын газар нь Онцгой комиссын хурлаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангана.

2.3. Хурлаар хэлэлцэх асуудал, гамшгийн нөхцөл байдлын мэдээллийг үнэн, зөв бодитой авч Онцгой комиссын удирдлага гишүүдэд шуурхай хүргэсэн байна.

2.4. Хурлаар хэлэлцэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулсан байна.

2.5. Хуралд танилцуулах мэдээлэл, материал товч тодорхой бичигдсэн байх

2.6. Хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн материал нь дор дурдсан бүрдүүлэлтийг хангасан байна.

А.архивын нэгж болгон хадгалах стандартын дагуу бэлтгэгдсэн, шаардлагатай тоогоор хувилж олшруулсан байх

Б.шийдвэрийн төсөл нь хууль тогтоомжид нийцсэн байх

В. төсөв, хөрөнгийн холбогдолтой асуудалд үнэн бодитой тооцоо судалгаа гаргасан байх

Гурав. Хурал хийх

3.1.Хурлыг Онцгой комиссын дарга удирдаж явуулна. Даргын эзгүйд Онцгой комиссын орлогч дарга эсвэл ажлын хэсгийн ахлагч, гишүүн даргална.

3.2.Хуралд Онцгой комиссын гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь ирснээр хүчин төгөлдөр гэж тооцно. Хэлэлцэх асуудлыг танилцуулахаас өмнө Онцгой комиссын шийдвэрийн биелэлтийг танилцуулна

3.3.Хурлыг Онцгой комиссын дарга, орлогч нээнэ. Хэлэлцэх асуудлын дарааллыг ОК-ын нарийн бичгийн дарга танилцуулна. Нэг асуудлыг хэлэлцэж дуусаад дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ.

3.4.Төлөвлөгөөнд ороогүй боловч хуралдаанаар нэн яаралтай хэлэлцэн шийдвэрлэх тухай Онцгой комиссын гишүүдээс санал гарвал хурал даргалагчийн зөвшөөрснөөр эсвэл олонх санал гаргасан нөхцөлд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж оруулна.

3.5.Хэлэлцэх асуудлын танилцуулгуудыг Онцгой комиссын нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулж бэлтгэлийг хангуулна.

3.6.Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариултыг дуусгасны дараа хурал даргалагчийн зөвшөөрсөнөөр санал гаргах ба нэг асуудлын талаар 3-аас илүүгүй санал гаргана Нэг удаа санал гаргах, үг хэлэх хугацаа нь гишүүн бүрт 5 минутаас хэтрэхгүй байна. Шаардлагатай гэж үзвэл хурал даргалагчийн зөвшөөрснөөр 3 минут сунгаж болно.

Дөрөв. Хурлын шийдвэр

4.1.Комиссын гишүүдийн санал, зөвлөмжийг хуралдааны тэмдэглэлд хэлсэн үгээр нь тодорхой тусгаж баталгаажуулалт хийнэ.

4.2.Хэлэлцсэн асуудалтай холбогдон гарах Онцгой комиссын даргын захирамж, албан даалгавар, төлөвлөгөө гарган хэлбэржүүлж болно.

4.3.Хэлэлцсэн асуудалтай холбогдон гарах захирамж, төлөвлөгөөний талаар эсрэг саналтай гишүүн өөрийн саналаа тусгайлан бичиж хурлын тэмдэглэлд хавсаргаж болно.

4.4.Хэлэлцсэн асуудлын талаар Онцгой комиссын дарга санал дүгнэлтээ нэгтгэн олонхийн саналыг үндэслэн шийдвэр гаргаж ажиллана.

4.5. Онцгой комиссын хурлаар хэлэлцүүлсэн асуудалтай холбогдон гарах Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын захирамж, албан даалгаврыг ажлын 8 цагт багтаан баталгаажуулан бэлэн болгож холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

Тав. Хурлын Явцыг баримтжуулах

5.1. Онцгой комиссын даргын шийдвэрийн төслийг Онцгой комиссын нарийн бичгийн дарга боловсруулан батлуулна.

5.2. Хурлын явц, хурал дээр гишүүдийн хэлсэн үг, гаргасан саналыг Онцгой комиссын нарийн бичгийн дарга дэлгэрэнгүй байдлаар хөтлөнө. / Хурлын тэмдэглэлийг 2 доошгүй албан хаагчаар хөтлүүлнэ /

5.3. Хурлын тэмдэглэлийг үнэн зөв хөтлөхийн тулд дуу хураагч, техник хэрэгсэл ашиглан түүнийгээ бичигт буулгах буюу хавсаргах цахим байдлаар хадгалж болно.

5.4. Хурлын явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийг Онцгой байдлын газрын дарга хянана.

5.5. Хурлын тэмдэглэлд дор дурдсан бичиг баримтыг хавсаргана.

А. тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт хэлэлцэх асуудлын төлөвлөгөө

Б. гишүүдийн ирцийн байдал /хурлаас хоцорсон болон хуралд оролцоогүй гишүүний нэр, шалтгаан/ болон хуралд оролцсон бусад хүний албан тушаал, нэрс

В. гишүүдэд тараасан материалын эх хувь

Г. хэлэлцсэн асуудалтай холбогдох судалгаа, тооцооны баримт бичиг, зураг төсөв, танилцуулга

5.6. Хурлын тэмдэглэлд:

- хурал болсон газар, эхэлсэн, дууссан он сар, өдөр, цаг
- хурлын нэмэлт танилцуулгын үндсэн буюу бичмэл хавсралт
- асуулт, хариулт
- гишүүдийн хэлсэн үг, санал, зөвлөмж
- Онцгой комиссын даргын дүгнэлт шийдвэр тусгагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 10...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДЭД СУМ
ХАРИУЦУУЛСАН ХУВААРЬ

д/д	Онцгой комиссын гишүүд	Хариуцсан сум
1	Аймгийн Засаг даргын орлогч	Хужирт
2	Тамгын газрын дарга	Бат-Өлзий
3	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Нарийнтээл
4	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Баруунбаян-Улаан
5	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Богд
6	Цэргийн штабын дарга	Өлзийт
7	УЦУОШАлбаны дарга	Хархорин
8	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Бүрд
9	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	Баянгол
10	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга	Баян-Өндөр
11	Эрүүл мэндийн газрын дарга	Есөнзүйл
12	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч	Уянга
13	Цагдаагийн газрын дарга	Тарагт
14	Тагнуулын ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймаг дахь хэлтсийн дарга	Гучин-Ус
15	Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга	Төгрөг
16	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Хайрхандулаан
17	Зооноз өвчин судлалын төвийн дарга	Зүүнбаян-Улаан
18	МУЗН-ийн салбарын дарга	Сант
19	Арвайхээр сумын Засаг дарга	Арвайхээр

Аймгийн Засаг даргын 2021 оны 10...
дугаар сарын 08-ны өдрийн 11188 дугаар
захирамжийн тавдугаар хавсралт



ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСЭГ

1. Газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх шуурхай ажлын хэсэг :

Ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч
- Онцгой байдлын газрын дарга
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- ӨВ АЗЗА, ТӨХК-ны дарга
- Цагдаагийн газрын дарга
- Тагнуулын хэлтсийн дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
- Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК-ны Өвөрхангай аймаг дахь газрын дарга
- ЭБЦТС, ТӨХК-ны салбарын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Улаан загалмайн хорооны дарга

Нарийн бичгийн дарга: -Онцгой комиссын нарийн бичгийн дарга
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн барилга хот байгуулалт, газрын харилцааны харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч
- Эрүүл мэндийн газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Мал эмнэлгийн газрын дарга

Гишүүд: - Онцгой байдлын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- ӨВ АЗЗА, ТӨХК-ны дарга
- Цэргийн штабын дарга
- Тагнуулын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Мэргэжлийн хяналтын дарга
- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
- Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Боловсрол, соёл урлагын газрын дарга
- ЭБЦТ сүлжээ ТӨХК-ны дарга
- Улаан загалмайн хороо
- Зооноз өвчин судлалын төвийн дарга
- Гамшиг болсон тухайн тухайн сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: -Онцгой комиссын нарийн бичгийн дарга

- Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

3. Дэд бүтэц техникийн холбогдолтой ослын үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Ахлагч: - Мэргэжлийн хяналтын газрын дарга

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга,

Гишүүд: - Тагнуулын хэлтсийн дарга

- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
- Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- ЭБЦТ сүлжээ ТӨХК-ны дарга
- Цэргийн штабын дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Гамшиг болсон тухайн сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: - Онцгой комиссын нарийн бичгийн дарга

-Аймгийн ерөнхий архектиктү

4.Зуд, өвөлжилт хүндэрсэн үед ажиллах ажлын шуурхай хэсэг:

Ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч

- ӨВ АЗЗА, ТӨХК-ны дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

- Онцгой байдлын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч
- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- МУЗН-ийн салбарын дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга
- Гамшиг болсон тухайн сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

- Онцгой комиссын нарийн бичгийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн

5. Объектын болон ой хээрийн түймрийн үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Ахлагч : - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

- Онцгой байдлын газрын дарга

Гишүүд: - Цагдаагийн газрын дарга

- Цэргийн штабын дарга

- ӨВ АЗЗА, ТӨХК-ны дарга

- Эрүүл мэндийн газрын дарга

- Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

- Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК-ны Өвөрхангай аймаг дахь газрын дарга

- Авто тээврийн төвийн дарга

- ЭБЦТС, ТӨХК-ны салбарын дарга

- Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

- Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Хууль зүйн хэлтсийн дарга

- Гамшиг осол болсон тухайн сумдын Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

-Онцгой комиссын нарийн бичгийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтсийн ахлах Мэргэжилтэн

6. Террорист халдлагаас сэргийлэх тэмцэх ажлын хэсэг:

Ахлагч: - Цагдаагийн газрын дарга

-Тагнуулын хэлтсийн дарга

- Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч

Гишүүд:

- Онцгой байдлын газрын дарга

- Хууль зүйн хэлтсийн дарга

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

- Мэргэжлийн хяналтын газрын дарга

- Эрүүл мэндийн газрын дарга

- Санхүү, төрийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

- Онцгой комиссын нарийн бичгийн дарга

- Цагдаагийн газрын дэд дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2021 оны 10...
дугаар сарын 08... ны өдрийн 1183 дугаар
захирамжийн зургаадугаар хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИ

№	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн нэр	Түшиглэн байгуулах мэргэжлийн байгууллагууд
1. Гамшгаас хамгаалах орон нутгийн алба		
1.	Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Байгаль орчин, аялал жуулчлалын газар Ус цаг, уур орчны шинжилгээний алба
2.	Барилга, хот байгуулалтын алба	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
3.	Зам, тээврийн алба	Авто тээврийн төв
4.	Хүн ам, нийгмийн хамгаалалтын алба	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
5.	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуйн газар
6.	Түлш, эрчим хүчний алба	ЭБЦТС ТӨХК-Өв дахь салбар
7.	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар
8.	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК
9.	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын газар
10.	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн газар
11.	Сурталчилгааны алба	Арвайхээр, Соёмбо, ӨВ лайв, Хас телевиз

2. Тусгай зориулалтын мэргэжлийн анги

Д/Д	Мэргэжлийн ангийн зориулалт	Ангилал	Чиг үүрэг	Хариуцах байгууллага
1.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	Яаралтай тусламжийн бүлэг	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
		Хээрийн эмнэлэг	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах	
		Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг	Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах	
		Эм	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг	

		эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг	болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах	
		Зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхтгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах	Зооноз өвчин судлалын төв
		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх	Улаан загалмайн хороо
		Анхны тусламжийн нөхөрлөл	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх	
2.	Нийгмийн хамгаалал	Хүүхэд хамгаалал боловсролын бүлэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Боловсрол, соёл урлагийн газар
		Өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
3.	Хүмүүнлэгийн тусламж	Дотоодын хүмүүнлэгийн тусламж, хувцас	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах, Гамшиг, ослын үед	Аймгийн Засаг даргын Тамгын газар

			хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах	
4.	Хэв журам сахиулах ажиллагаа	Хэв журам сахиулах бүлэг	Гамшиг, ослын үед нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах	Цагдаагийн газар
		Тусгай бүлэг	Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих, ухуулга, сурталчилгаа хийх	Тагнуулын хэлтэс
5.	Санхүү нөөц хангалт	Санхүү нөөцийн бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх Гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, Хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах	
		Хүнсний хангалтын бүлэг	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах	"Дэлгэрэх хүнс" ХХК
		Тээврийн бүлэг	Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ	Автотээврийн газар

			үзүүлэх	
		Шатахуун хийн түлш хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх	НИК Петровис
6.	Орон байр, Нүүлгэн шилжүүлэлт түр байр	Орон байр, Нүүлгэн шилжүүлэлт, Хорогдох байрны бүлэг	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байраар хангах, Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах, Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах	Газрын харилцаа, барилга хот байгуулалт Биеийн тамир спортын газар
		Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	Хийн хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлтгэрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах	Хүнс хөдөө аж ахуйн газар
8.	Хүнс хөдөө аж ахуй	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Мал амьтны халдварт, гоц халдварт өвчлөлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг танилганд хийж оношийг тогтоох, тусалраах, хязгаарлалт хорио цэврийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх	Мал эмнэлгийн газар
		Ариутгал халдваргүйжүүлэлтийн бүлэг	Мал амьтан, ургамлын халдварт өвчлөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор	

			халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх	
		Ариутгал халдваргүйжүүлэлтийн бүлэг	Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх	
9.	Гал түймэр унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах бүлэг	Объектын болон ой, хээрийн түймрээс хүний амь нас, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах ажлыг зохион байгуулах	Гал түймэр унтраах, аврах 12, 45 дугаар анги
10	Усны сан бүхий газар, уст цэг хамгаалах ажиллагаа	Цэвэр, бохир усны засварын бүлэг	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх	Онги ус суваг ОНӨААТҮГ
		Уст цэг хамгаалах бүлэг	Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах	
11	Дулаан хангамж	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	Дулааны эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх	
12	Цахилгаан хангамж	Цахилгаан шугам сүлжээний засварын бүлэг	Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугаманд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх	ЭБЦТС, ТӨХК-ний салбар
13	Зам, гүүрийн засвар үйлчилгээ	Зам, гүүрийн засварын бүлэг	Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх	"ӨВ АЗЗА" ТӨХК
14	Инженер, тэсэлгээ	Инженер, тэсэлгээний бүлэг	Аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх. (цасны	ЗХ-ний 256 дугаар анги

			нуранги, мөсний хахаа зайлуулах, нурангинд дарагдсан зам гарцыг чөлөөлөх гэх мэт)	
15	Цацраг химийн хяналт	Цацраг химийн хяналтын бүлэг	Гамшиг, ослын голомтод цацраг, химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшингийн хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх	Мэргэжлийн хяналтын газар
16	Харилцаа холбоо, зарлан мэдээлэл	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК
17	Мэдээлэл сурталчилгаа	Мэдээлэл сурталчилгааны бүлэг	Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах	Арвайхээр, Соёмбо, ӨВ лайв, Хас телевиз
18	Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгаа	Иргэний бүртгэл мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх	Улсын бүртгэлийн хэлтэс
		Статистик мэдээллийн бүлэг	Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо судалгаа гаргах	Статистикийн хэлтэс
19	Нисэх буудлын аюулгүй байдал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Агаарын хөлгийн хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг хангуулах, гамшиг, ослын үед нислэгийн бүсэд аврах, хор уршгийг арилгах, гал түймрийг унтраах, нислэгийн зурвасыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах	Нисэх буудлын дарга